



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 448

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 11 нэрийн нийт 1,340,855,925.00 (нэг тэрбум гурван зуун дөчин сая найман зуун тавин таван мянга есөн зуун хорин таван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Говь-Алтай аймгийн мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Гантулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 09 дүгээр сарын -
ны ... өдрийн ... дугаар тогтоолын
хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН, ГОВЬ-АЛТАЙ
АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ӨМЧИД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламж /хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ/-ний нэр	Ашиглалтанд орсон он	хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Газар эзэмших эрх /660 м2/	2019	13,200,000.00
2	Конторын барилга	2019	933,518,946.00
3	Гаражийн барилга		67,783,378.00
	Барилгын дүн		1,001,302,324.00
4	Дулааны шугам	2020	63,636,565.00
5	Цэвэр усны шугам	2020	53,898,871.00
6	цахилгаан хангамж	2020	3,580,328.00
7	Ариутгах татуурга	2020	12,822,515.00
8	Холбооны шугам	2020	65,422,621.00
	Шугам сүлжээний дүн		199,360,900.00
9	Гадна хашаа	2020	27,065,537.00
10	Явган хүний зам талбай	2020	78,363,882.00
11	Гадна гэрэлтүүлэг	2020	21,563,282.00
	Нийтийн эзэмшлийн дүн		126,992,701.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,340,855,925.00 (нэг тэрбум гурван зуун дөчин сая найман зуун тавин таван мянга есөн зуун хорин таван)